

Сайнуу Ток

Хэрэглэгчийн гарын авлага

Гарчиг

Сайнуу ток суулгах.....	3
Сайнуу Ток татах	3
Сайнуу Ток суулгах	3
Сайнуу Ток гарч болох саатал.....	7
Чихэвч микрофон шалгах.....	7
Сайнуу Ток програмтай ажиллах заавар.....	9
Сайнуу Ток програмыг ажилуулах.....	9
Сайнуу Ток програмд нэвтрэх.....	10
Сайнуу Ток програмын дэлгэцийн хэсэг	11
Сайнуу ток ашиглан залгах	11
Хэрхэн залгах вэ?.....	11
Залгалт хийх үед гарах тайлбар.....	12
Утасны лавлах цэс	12
Алдаа	13
Алдаа 1	13
Алдаа 2	13
Сайнуу Ток товчлуурын хэсэг.....	14

Сайнуу ток суулгах


Сайнуу Ток татах

Үйлчилгээний хэсэг дээрээс очиж хэрэглэгчийн нэр нууц үг үүсгүүлсэн бол одоо татаж суулгаад ярих л үлдлээ.

Сайнуу Ток татаж авахын тулд манай веб хуудасны

<http://www.asiatele.mn/service/sainuutalk.html> хуудсан дахь **энд ДАРЖ татаж авна уу** гэсэн хэсэг дээр дарна.

Эсвэл **Internet Explorer** дээрээ http://www.asiatele.mn/Sainuu_Talk_mn.msi гэж бичээд Enter дархад доорх цонх гарч ирнэ. **Run** хийвэл суулгах ба **Save** хийвэл хадгалж авна.



Зураг1-1

Сайнуу Ток суулгах

Зураг 1-1 дээрх **Run** товчийг дарж Сайнуу Ток суулгана аа. **Run** товчийг дархад доорх цонх нээгдэнэ.



Зураг 1-2

Зураг 1-2 дахь **Run** товчийг дарсанаар үргэлжлүүлэн суулгах ба **Don't Run** гэвэл суулгалгүйгээр гарна.

Та цааш нь суулгана гэж сонгосон бол дараах цонх гарч ирнэ.




Зураг 1-3

Зураг 1-3 дээр Cancel дарж суулгах ажиллагааг зогсооно. Next дарж цааш нь үргэлжлүүлнэ.

Next дархад Зураг 1-4 нээгдэнэ.


Энд **Browse** товчийг дарж суулгах замаа заана өгнө. **Disk cost** товчийг дарж өөрийн компьютерын дискнүүдийн зайг харж болно. Хэрэв та **Folder:** гэсэний доорх анхны утгаар гарч ирсэн газар суулгах бодолтой байгаа тохиодолд дээрх **Browse** сонголтыг өөрчлөхгүйгээр явуулах хэрэгтэй.

Everyone гэж сонгоод суулгах юм бол таны компьютер дээрх бүх хэрэглэгч Сайнуу Ток програмыг ашиглах боломжтой болно. Харин **Just me** гэсэн сонголтоор суулгах юм бол зөвхөн та л хэрэглэх боломжтой гэдгийг анхаарна уу.




Зураг 1-4

Одоо өөрт тохирох сонголтуудаа хийж дууссан бол **Next** товчийг дарж үргэлжлүүлнэ.




Зураг 1-5

Зураг 1-5 дээрх цонхны **Next** товчийг дарна. Ингэснээр дискэн дээр хуулж эхэлнэ.



Зураг 1-6

Зураг 1-6 уншиж дуусаад доохр зураг гарч ирнэ.



Зураг 1-7


Зураг 1-7 дээр **Close** гэсэн товчийг дарж суулгах ажиллагаа дуусна.

Сайнуу Ток гарч болох саатал

Сайнуу Ток програм нь интернэтийн сүлжээнд 5060, 1800 гэх мэт портыг ашиглан ажилладаг учир таны хэрэглэж байгаа интернэт чинь энэ портуудыг хаасан байж болох талтай юм. Ийм хаалтыг таны интернэт авч буй ISP дээр эсвэл таны сүлжээнд хэрэглэж буй төхөөрөмжүүд дээр хийгдсэн байдаг.

Энэ тохиолдолд:

1. Таны яриа холбогдсон хүндээ сонсогдоод та яриж байгаа хүнийхээ дууг сонсохгүй байх.
2. “Дуудаж байна” гэсэн бичиг гарч ирсэн боловч танд ямар нэг дуу сонсогдохгүй байх гэх мэт хүндрэл гарч магадгүй.




Дээрх тохиолдолд та Сайнуу токын дараах хувилбарыг татаж авч хэрэглээрэй.

Сайнуу Ток програмыг татаж авах: http://www.asiatel.mn/SainuuTalk_en_vpn.msi


Жич: Энэ програм нь English хэл дээр байгаа. Эсвэл манай вебийн Энд **дарж** English хувилбарыг нь татаж авна уу гэсэн хэсгээс суулгах боломжтой

Дээрх хоёр тохиолдол мөн таны хэрэглэж байгаа компьютерийн дууны картаа таниагүй үед гарч болдог. Дууны картаа танисан эсвэл таниагүй гэдгийг шалгахдаа чихэвч микрофоны ажиллагаа хэвийн байгаа эсэхийг үзэх хэрэгтэй.

Чихэвч микрофон шалгах



1. Чихэвч микрофоноо шалгахын тулд сум заасан товчин дээр дархад доорх цонх нээгдэнэ.
2. Next гэсэн товчийг дарна.
3. Гарч ирсэн цонхноос дахин Next дарна.





4. Доорх цонхны **Microphone**: гэсэн хэсгээс өөрийн дууны картны нэрийг сонгоно.

5. **Speakers**: гэсэн хэсгээс өөрийн дууны картны нэрийг сонгоод **Next** дарна.



6. **Speaker** -ээ шалгахын тулд **Click to Test Speakers** гэж дархад танд дуут дохио өгнө.

7. Одоо **Microphone** шалгахын тулд **Next** гэсэн товчин дээр дарна.





8. Доорх сумаар заасан хэсэг дээр таны микрофоны ажиллагаа харагдаж байна. Хэрэв энэ хэсэгт ногоон судал гүйхгүй байгаа бол таны микрофон ажиллахгүй байна гэсэн үг юм.

9. Одоо залгахад ямарч асуудаслгүй ээ. **Next** дарж шалгах ажиллагааг дуусгана.



Сайнуу Ток програмтай ажиллах заавар

Сайнуу Ток програмыг ажилуулах

Хоёр өөр аргаар Сайнуу Токоо програмаа ажилуулж болно.

1. **Start** цэсний **All Programs** гэж дархад **Sainuu Talk** гээд суучихсан хэлбэрээр байгаа. Зураг 2-1 ийг харна уу.



Зураг 2-1


2. Шууд дэлгэц дээр Сайнуу Ток програм суусан хэлбэрээр байгаа. (Сумаар харуулав) Зураг 2-2 ийг харна уу.



Зураг 2-2

Сайнуу Ток програм дээрээ дарсанаар нэвтрэх цонх гарч ирнэ.

Сайнуу Ток програмд нэвтрэх



Хэрэглэгчийн
нэрээ бичнэ үү

Нууц үгээ
оруулна уу

Хэрэглэгчийн нэр нууц үгээ оруулаад **нэвтрэх** товчин дээр дарна.
Жич: Хэрэглэгчийн нэр, нууц үгийг үйлчилгээний төвөөс авна.

Сайнуу Ток програмын дэлгэцийн хэсэг

Амжилттай нэвтэрсэн бол дараах цонх гарч ирнэ.

Энд доорх зүйлсийг анхаарна уу.

1. ”**Боломжит мин** ---- “ гэдэг таны залгасан дугаарлуу яриж болох хамгийн их хугацаа.
2. “**Минут 00:00:00**” Та залгаснаас хойш хэдэн минут өнгөрч байгааг харуулна.

Энд “Цаг:Минут:Секунд” харуулна.

3. “**Хаашаа**” Таны залгаж байгаа улсын нэрийг харуулна.
4. “**Баланс**” таны дансны үлдэгдэл хэдэн төгрөг байгааг харуулна.
5. “**Тариф**” Залгаж буй тухайн улс руу 1 минутанд хэдэн төгрөгөөр ярих үнэ болно.

Дээрх жишээнд харуулсанаар та 152 төгрөгөөр АНУ-руу нэг минутанд 25 төгрөгөөр нийт 6 минут ярих боломжтой байна.



Сайнуу ток ашиглан залгах

Хэрхэн залгах вэ?

1

The diagram illustrates the call control buttons on the Сайнуу Talk interface. Arrows point from text boxes to the corresponding buttons on the keypad:

- Та 0-9 хүртлэх дугаартай товчнуудыг ашиглан залгах дугаараа цуглуулна.** (Points to the numeric keypad buttons 0-9)
- Сум заасан цонхон дээр даран хулганы зүүн товчыг дарж компьютерын гараас залгах дугаараа оруулж болно.** (Points to the ЗАЛГА button)
- Дугаараа оруулж дуусаад ЗАЛГА товчин дээр дарж дуудлага хийнэ.** (Points to the ЗАЛГА button)
- Дуудлагаа төгсгөх бол САЛГА товчин дээр дарна уу** (Points to the САЛГА button)
- Та оруулсан дугаараа АРИЛГА товчыг дарж арилгаж болно.** (Points to the АРИЛГА button)

Залгалт хийх үед гарах тайлбар



Таны залгасан дугаар дуудаж байгааг харуулж байна.




Дансны үлдэгдэл дууссан эсвэл та салгасан дохиолдолд дээрх бичиг гарч ирнэ.

Утасны лавлах цэс



Утасны лавлах:
Та өөрийн байнга ярьдаг дугааруудаа үүнийг ашиглан хадгалж мөн эндээсээ залгаж болно.
Энд дарахад доорх цонх нээгдэнэ.

Хадгалсан дугаар дээрээ 2 ойрхон дархад шууд залгагдана.



Нэр, утасны дугаараа оруулаад энэ товчин дээр дарж хадгална.

Бүртгэсэн дугаараа устгах.

Энд дарж хадгалах нэрээ оруулна

Хадгалах утасны дугаараа 00 гээд улсын код, хотын кодтой нь оруулна уу
Анхааруулга: Гар утасны дугаарт хотын код хийхгүй

Алдаа

Алдаа 1

Хэрэв таны нууц үг эсвэл Хэрэглэгчийн нэр буруу бол доорх алдаа гарна.



**Хэрэглэгчийн нэр
нууц үг буруу байна.**

Зураг 3-1

Алдаа 2

Интернэтийн сүлжээ тасарсан үед гарах алдаа.




**Unable to register to SIP server:
гэсэн алдаа гарч ирвэл Таны компьютерийн
интернэтийн сүлжээ тасарсан интернэтэд
орохгүй байна гэсэн үг юм аа.**

Зураг 3-2

Жич: Энэ алдаа танай хэрэглэж байгаа интернэт удаан эсвэл таны хэрэглэж байгаа интернэт кафенд хэрэглэж байгаа програмаас болж бас гардаг.

Сайнуу Ток товчлуурын хэсэг



Залгах заавар

- Суурин утасруу залгах

- 00 => улсын код => хотын код => утасны дугаарыг оруулан **ЗАЛГА** товчыг даран холбогдоно.

- Гар утасруу залгах

00 => улсын код => утасны дугаарыг оруулан **ЗАЛГА** товчыг даран холбогдоно.

Жишээ: Солонгос улсын гар утасруу: 00 => 82 => гар утасны дугаар **ЗАЛГА**

Хэрэв таны залгалт болохгүй ямар нэг асуудал гарч байгаа бол та Сайнуу Токоосоо **111**-руу холбогдож оператороос зөвөлгөө авна уу.